



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.005>

Contemporary United Nations Peacekeeping and the Social Protection of Peacekeepers

B. Erdenebat¹, D. Maitsetseg²

¹Major General, Force Commander, Gang Suppression Force, Republic of Haiti

²Research Fellow, Peace Operations Research Center, Defense Research Institute of Mongolia

Received: 16 June 2026

Revised: 02 July 2026

Accepted: 20 July 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Driven by escalating global geopolitical tensions and the evolving nature of armed conflicts, the operational environment of United Nations peacekeeping has become unprecedentedly complex and high-risk. This paper analyzes transformations in the contemporary strategic environment, mandate expansion, budgetary constraints, and technological paradigm shifts aimed at mitigating personnel shortages, drawing on empirical insights from the United Nations Peacekeeping Force in Cyprus (UNFICYP). At the same time, the study examines the potential adverse impacts on the lives, health, psychological well-being, and family relationships of peacekeepers deployed in high-risk environments, as well as related social protection challenges. The study argues that the social protection of peacekeepers should not be viewed merely as a narrow framework of compensation and welfare; rather, it should be recognized as a strategically important pillar in ensuring the sustainability of the global peacekeeping architecture.

Keywords: UN Peacekeeping, social protection, dual system, Protection of Civilians (POC), Post-Traumatic Stress Disorder (PTSD), technology-driven operations.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны өнөөгийн орчин ба энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал

Б.Эрдэнэбат¹, Д.Майцэцэг²

¹Бүгд Найрамдах Хаити Улс дахь Гэмт хэргийн бүлэглэлтэй тэмцэх олон улсын цэргийн ажиллагааны Цэргийн хүчний командлагч, Хошууч генерал

²Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Энхийн ажиллагааны судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан


ХУРААНГУЙ

Дэлхийн геополитикийн хурцадмал байдал, зэвсэгт мөргөлдөөний хувьслыг дагаад Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны орчин урьд өмнө байгаагүйгээр төвөгтэй, өндөр эрсдэлтэй болж байна. Энэхүү өгүүлэлд орчин үеийн энхийг сахиулах

ажиллагааны стратегийн орчны өөрчлөлт, мандатын өргөжилт, төсвийн хямрал хийгээд хүн хүчний хомсдолыг тэнцвэржүүлэх технологийн шилжилтийн асуудлыг Кипр дэх НҮБ-ын ажиллагааны (UNFICYP) практик жишээн дээр тулгуурлан дүн шинжилгээ хийсэн болно. Үүний зэрэгцээ, өндөр эрсдэлтэй орчинд үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчдын амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүй болон гэр бүлийн харилцаанд үүсч болзошгүй сөрөг үр дагаврууд, тэдгээртэй холбоотой нийгмийн хамгааллын асуудлыг авч үзэв. Энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал нь гагцхүү нөхөн олговор, халамжийн хүрээний ойлголт бус, харин дэлхийн энх тайвныг сахин хамгаалах байгууллын тогтвортой байдлыг баталгаажуулахад стратегийн чухал ач холбогдолтой байх ёстойг энэхүү судалгаагаар нотлон харуулахыг зорилоо.

Түлхүүр үгс: НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа, нийгмийн хамгаалал, хосолмол тогтолцоо (Dual system), энгийн иргэдийг хамгаалах (POC), сэтгэл санааны гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD), технологид суурилсан ажиллагаа

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны өнөөгийн орчин. Дэлхийн аюулгүй байдлын орчин өнөөдөр геополитикийн өрсөлдөөн эрчимжих, зэвсэгт мөргөлдөөн олшрох, олон улсын дэг журмын тодорхой бус байдал нэмэгдэх зэрэг шинжээрээ Хүйтэн дайнаас хойших хамгийн сорилттой үе шаттай нүүр тулж байна гэж олон улсад үзэж байна. Тухайлбал, “Institute for Economics and Peace” (Эдийн засаг, энх тайвны хүрээлэн)-ээс эрхлэн гаргасан Global Peace Index 2025 тайланд дурдсанаар, 2023 онд дэлхий дахинд төрийн оролцоотой 59 идэвхтэй зэвсэгт мөргөлдөөн бүртгэгдсэн нь Дэлхийн II дайнаас хойших хамгийн өндөр үзүүлэлт болж, олон улсын аюулгүй байдлын орчны тогтворгүй байдал эрчимжиж байгааг харуулж байгаа юм.



Зураг 1. 2026 онд улам хурцах магадлалтай зөрчил, мөргөлдөөний гол бүсүүд

Хувьсан өөрчлөгдөж буй аюулгүй байдлын орчин нь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны үзэл баримтлал, чиг үүргийг углуургаар нь шинэчлэх бодит хэрэгцээг бий болгож буй гол хүчин зүйлсийн нэг юм. Анх хил дамнасан, улс хоорондын уламжлалт дайсгалыг зогсоох, гал зогсоох шугамыг хянах зорилгоор үүсгэн байгуулагдсан энхийг сахиулах ажиллагаа нь өдгөө дотоодын зэвсэгт мөргөлдөөн, үндэстэн дамнасан терроризм, засаглалын гүнзгий хямрал зэрэг олон хэмжээст,

тэгш бус (асимметри) аюул заналтай нүүр тулах шаардлагатай болжээ.

Гэвч их гүрнүүдийн геостратегийн өрсөлдөөн, ашиг сонирхлын зөрчил нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гаргах түвшинд хүчтэй нөлөөлж, ажиллагааны мандатыг батлах, сунгах үйл явцад сөргөөр нөлөөлж байна. Үүний үр дагаварт НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны тулгуур болсон “Хүлээн зөвшөөрөгдөх”, “Тал үл хамаарах буюу төвийг сахих”, өөрийгөө хамгаалах болон мандатаас бусад үед “Хүч үл хэрэглэх” гэсэн суурь зарчмуудыг хэрэгжүүлэхэд улам бүр төвөгтэй болж байна. Тухайлбал, Өмнөд Судан зэрэг мөргөлдөөний бүсүүдэд төрийн болон зэвсэгт талууд иргэдийн эсрэг хүч хэрэглэж буй нөхцөл байдал нь НҮБ-ын энхийг сахиулагчдын энгийн иргэдийг хамгаалах мандатыг хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учруулах болов. Үүний зэрэгцээ, хүлээн авагч улсын зөвшөөрөлд суурилсан энхийг сахиулах ажиллагааны онцлогоос шалтгаалан улс төрийн дэмжлэг сулрах, үйл ажиллагааны хязгаарлалт нэмэгдэх нь мандатын эрх зүйн болон үйл ажиллагааны орон зайг хумьж байна (Duursma A., et al. 2024).

Орчин үеийн зэвсэгт мөргөлдөөнүүд нь төрийн бус зэвсэгт бүлэглэлүүд, террорист сүлжээ болон зохион байгуулалттай гэмт хэргийн оролцоотойгоор улам төвөгтэй шинжтэй болж, олон тохиолдолд иргэний дайны хэлбэр давамгайлах хандлагатай болсон. Мали (MINUSMA), Судан (UNIMID), Хаити (MINUSTAH, BINUH) зэрэг орнуудад хэрэгжиж байсан НҮБ-ын энхийг сахиулах болон улс төрийн дэмжлэгийн ажиллагаанууд нь улс төрийн зөвшилцөл сулрах, аюулгүй байдлын нөхцөл дордох, мөн хүлээн авагч улсын хамтын ажиллагааны хүрээ өөрчлөгдөх зэрэг хүчин зүйлсийн улмаас үе шаттайгаар дуусгавар болсон эсвэл өөр хэлбэрт шилжсэн (United Nations. 2023). Эдгээр ажиллагааны бууралт болон шилжилт нь зарим бүс нутагт аюулгүй байдлын орон зайг сулруулж, зэвсэгт болон гэмт хэргийн бүлэглэлүүдийн нөлөөг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байгаа юм. Үүний үр дагаварт орон нутгийн тогтворгүй байдал гүнзгийрч, дүрвэгсдийн урсгал нэмэгдэх, хууль бус шилжилт хөдөлгөөн эрчимжих замаар бүс нутгийн болон хөрш орнуудын аюулгүй байдлын орчинд шууд болон шууд бус дарамт үзүүлэх болсон.

Энэхүү тогтворгүй байдал нь энхийг сахиулагчдыг урьд өмнө хэзээ ч байгаагүй өндөр эрсдэлтэй, дайсагнасан бүсэд үүрэг гүйцэтгэхэд хүргэж байна. НҮБ-ын далбаа, цэнхэр дуулга нь аюулгүй байдлын баталгаа байхаа больж, харин ч халдлагын “бай” болон хувирчээ. Тухайлбал, Ливан дахь НҮБ-ын UNIFIL ажиллагааны хүрээнд үүрэг гүйцэтгэж буй Индонезийн алба хаагчид (UNFILL reports. 2026), Абьей дахь UNISFA ажиллагаанд Бангладешийн алба хаагчид ассиметрик буюу тэсрэг бөмбөг, отолт, шууд гал нээх, дроны халдлагад өртөж, амь насаа алдах, шархдах тохиолдол (UNISFA Reports. 2025) гарсан. Үүнтэй зэрэгцэн мэдээллийн орчны дайн эрчимжиж, зохион байгуулалттай хуурамч мэдээлэл тараах замаар орон нутгийн иргэдийг НҮБ-ын эсрэг турхирах ажиллагаа хээрийн нөхцөлд хамгийн том “үл үзэгдэх дайсан” болж байна (UNDPO., 2026).

Аюулгүй байдлын орчны энэхүү эрс тэс өөрчлөлт нь НҮБ-ын ЭСА-ны чиг үүргийг үндсээр нь өөрчлөхөд хүргэв. Уламжлалт хяналтын мандатаас татгалзаж, “Энгийн иргэдийг хамгаалах” (Protection of Civilians - POC) нь дийлэнх ажиллагааны стратегийн гол цөм болсон. Үүний дотор хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, мөргөлдөөнөөс үүдэлтэй бэлгийн хүчирхийллээс (CRSV) урьдчилан сэргийлэх нь энхийг сахиулагчдын тэргүүлэх үүрэг болжээ.

Үүнээс гадна мандатын цар хүрээ өргөжиж, зэвсэгт бүлэглэлтэй шууд тэмцэх, орон нутгийн цагдаа, аюулгүй байдлын байгууллагыг сургах, улс орны төрийн институцийг дахин бэхжүүлэх зэрэг цогц зорилтууд тавигдах болсон. Өөрөөр хэлбэл, орчин үеийн ЭСА нь сонгодог “энхийг сахиулах” хэлбэрээсээ алсарч, хүч хэрэглэн мандатаа хэрэгжүүлэх буюу “Энхийг хүчээр тогтоох” (Peace enforcement) нарийн төвөгтэй, байлдааны шинжтэй ажиллагаа руу шилжиж байна.


НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанууд нь сүүлийн арван жилд өсөн нэмэгдэж буй мандатын шаардлага, улам төвөгтэй болсон зэвсэгт мөргөлдөөнүүдийн зэрэгцээ санхүүгийн болон хүний нөөцийн тогтвортой байдлын дарамтад орж байна. НҮБ болон олон улсын судалгааны SIPRI байгууллагын статистикаас үзэхэд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа нь 2010-аад оны дунд үед 100,000 гаруй алба хаагчтай байсан нийт бүрэлдэхүүн 2020 оноос хойш тогтмол буурч, 2025 оны эцэс 2026 оны эхэн үеийн байдлаар ойролцоогоор 75,000 - 80,000 орчимд хүрч, сүүлийн 15 -20 жилийн хамгийн доод түвшинд хүрэв. Энэхүү бууралт нь зарим ажиллагааны хаалт, мандатын шилжилт, мөн гишүүн орнуудын хугацаа хэтэрсэн төлбөр болон төсвийн асуудалтай холбоотой бөгөөд энэ нь НҮБ-ын энхийг сахиулах чадавхийг хязгаарлах хүчин зүйл болж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерриш 2025–2026 онд байгууллага ноцтой санхүүгийн дарамттай тулгарч байгааг анхааруулж, төсөв танах, ажилтны тоог бууруулах зэрэг арга хэмжээ санал болгосон. Энэ хүрээнд 2026 оны эхний хагаст гэхэд дэлхийн 9 томоохон ЭСА-нд үүрэг гүйцэтгэж буй 50,000 гаруй алба хаагчаас 13,000 - 14,000 орчим цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүнийг буюу нийт хүчний 25 орчим хувийг эргүүлэн татсан ([UN Reports., 2026](#)). Үүн дээр нэмээд НҮБ ирэх санхүүгийн жилд төсвөө дахин 15 хувиар бууруулахаар төлөвлөж байгаа нь урт хугацаанд үргэлжилж буй ажиллагаануудын үр нөлөө, орон нутагт үзүүлэх хамгаалалтын цар хүрээнд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, цөөхөн бие бүрэлдэхүүнээр илүү өргөн уудам нутаг дэвсгэрт, илүү аюултай даалгавар гүйцэтгэх шаардлага гарч байгаа нь энхийг сахиулагчдын эрсдэлийн түвшнийг шууд нэмэгдүүлж байгаа юм.

Ийнхүү биет хүний нөөцийн хомсдолд орж, аюулгүй байдлын эрсдэл эрс нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд ажиллагааны чадавхыг тэнцвэржүүлэн хадгалах гол гарцуудын нэг нь “Технологид суурилсан ажиллагаа”-нд шилжих явдал болоод байна. Тиймээс ч орчин үеийн ЭСА-нд нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (UAV/Дрон)-ийг хяналт, тагнуулын зориулалтаар өргөнөөр ашиглаж, дижитал мэдээллийн систем, хиймэл оюун ухаан (AI) болон кибер аюулгүй байдлын арга хэрэгслийг үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон нэвтрүүлж байна. Эдгээр дэвшилтэт технологи нь мэдээлэл боловсруулах хурд, үнэн зөв байдлыг эрс сайжруулаад зогсохгүй, алба хаагчдын амь насыг шууд эрсдэлд оруулахгүйгээр нөхцөл байдлыг алсаас хянах боломжийг олгож байгаа юм.

Энэхүү өөрчлөлтийн мөн чанарыг НҮБ-ын Кипр дэх энхийг сахиулах ажиллагааны (UNFICYP) жишээн дээр авч үзэх боломжтой. Тус ажиллагааны хариуцсан бүс болох Киприйн тусгаарлах зурвас (Buffer Zone) нь ойролцоогоор 186 километр үргэлжилдэг бөгөөд газарзүйн байршлаас хамааран өргөн нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал, хөдөө орон нутгийн зарим хэсэгт тусгаарлах зурвасын өргөн 4.7 километр хүрдэг бол нийслэл Никосия хотын бүсэд ердөө 4 метр хүртэл

нарийсдаг. Ийм газарзүйн онцлог нь мөргөлдөгч талуудын цэргийн хүчийг ойр байрлах нөхцөлийг бүрдүүлдэг, мөн аливаа үл ойлголцол, жижиг хэмжээний зөрчил богино хугацаанд хурцадмал байдалд шилжих эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймээс энхийг сахиулагчид зөвхөн ажиглалт, хяналтын үүрэг гүйцэтгэхээс гадна мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, талуудын хооронд итгэлцлийг хадгалах, нөхцөл байдлыг тогтворжуулах чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулах шаардлагатай болно (UNFICYP, 2024).

Нарийвчилбал, Киприйн тусгаарлах зурвасын хойд хэсэгт байрлах Туркийн Бүгд Найрамдах Хойд Кипр Улсын нутаг дэвсгэрт Туркийн эх газрын армийн сайн тоноглогдсон ойролцоогоор 25,000 цэргийн бүрэлдэхүүн, түүнчлэн Туркийн Киприйн аюулгүй байдлын хүчний 9,000 орчим байнгын болон 26,000 орчим нөөц бүрэлдэхүүн байрлаж байна. Харин өмнөд хэсэгт байрлах Бүгд Найрамдах Кипр Улсын талд Үндэсний гвардын 10,000 орчим байнгын бүрэлдэхүүн, 50,000 орчим дайчилгааны нөөц хүчин, мөн Грекийн цэргийн хүчний (ELDYK) ойролцоогоор 1,000 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. Ийнхүү Киприйн арал дээр нийтдээ 120,000 орчим цэргийн болон дайчилгааны нөөц хүчин төвлөрсөн нөхцөлд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа хэрэгжиж байгаа нь тус ажиллагааны аюулгүй байдлын орчны онцлогийг харуулж байгаа юм. Ийм хэмжээний цэргийн хүчний төвлөрөл бүхий бүсэд энх тайвныг сахиулах зорилгоор олон тооны энхийг сахиулагч байршуулах нь практик болон санхүүгийн хувьд үр ашиггүй тул НҮБ-ын хүчин орчин үеийн технологид суурилсан хяналт, ажиглалтын арга хэрэгслийг үйл ажиллагаандаа өргөн ашиглаж байна. Энэ нь хязгаарлагдмал хүний нөөцөөр өргөн уудам бүс нутгийг тасралтгүй хянах, нөхцөл байдлын талаарх бодит цагийн мэдээлэл цуглуулах, улмаар болзошгүй хурцадмал байдлаас урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлдэг.



Зураг 2. UNFICYP ажиллагааны бүс дэх сөргөлдөгч талуудын (OPFOR) цэргийн байрлал

Гэвч технологийн дэвшил, үйл ажиллагааны шуурхай байдал нь Кипр дэх

мөргөлдөөнийг удирдан чиглүүлэхэд дангаараа хангалтгүй юм. Учир нь энхийн ажиллагаа нь зөвхөн бодит аюулгүй байдлыг хангах бус, улс төрийн туйлын эмзэг орчинд мөргөлдөгч талуудын итгэлцлийг бэхжүүлж, НҮБ-ын төвийг сахисан байр суурийг алхам тутамд баталгаажуулахыг шаарддаг. Үүнийг сахин хамгаалахад дипломат ёс зүй маш чухалаар тавигддаг болохыг доорх зурагт дурдсан үйл явдал тод харуулна. Иймд эдгээр нарийн төвөгтэй, эмзэг орчинд ажиллагааны үр нөлөөг бүрэн хангахын тулд орчин үеийн технологийн шийдэл, олон талт зохион байгуулалтыг иргэн-цэргийн хамтын ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай.




Зураг 3. НҮБ-ын энхийг сахиулах хүчний командлагч асан, хошууч генерал Ингрид Гжерде Хойд Киприйн Туркийн талын Аюулгүй байдлын хүчний дээд командлагчтай хийсэн уулзалтын үеэр Турк болон Хойд Киприйн далбааны өмнө авхуулсан энэхүү зураг нь Грекийн Кипрчүүдийн дургүйцлийг төрүүлэв. Үүний дараа тэд Гжердег “хүлээн зөвшөөрөх боломжгүй хил хязгаарыг давсан” хэмээн мэдэгдэж, албан ёсоор эсэргүүцэл илэрхийлсэн байна.

Өнөөгийн байдлаар Кипр Улс дахь Тусгаарлах бүсэд орчин үеийн цэргийн зориулалттай 360 гаруй ухаалаг камерыг суурилуулж, 24 цагийн цахим хяналтыг тогтоосон. Үүний зэрэгцээ тус ажиллагаа нь цэргийн бүрэлдэхүүн, НҮБ-ын Цагдаагийн бүрэлдэхүүн (UNPOL), иргэний асуудал хариуцсан бүрэлдэхүүн болон ажиллагааны дэмжлэгийн бүтэц гэсэн харилцан уялдаа бүхий олон талт тогтолцоонд тулгуурлан хэрэгждэг. Ялангуяа иргэний бүрэлдэхүүн нь хоёр талын хамтын ажиллагааг дэмжих, буфер бүс дэх газар ашиглалт, хүмүүнлэгийн болон иргэний асуудлыг зохицуулах, орон нутгийн иргэдийн хоорондын харилцаа, итгэлцлийг бэхжүүлэх замаар хурцадмал байдлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийнхүү UNFICYP нь зөвхөн цэргийн ажиглалт, хяналтаар хязгаарлагдахгүйгээр аюулгүй байдал, иргэний хамтын ажиллагаа, итгэлцлийг нэгтгэсэн иж бүрэн энхийг сахиулах загварыг хэрэгжүүлж байна.

Энхийг сахиулах ажиллагааны шинэ хандлага. Өнөөгийн дэлхий нийтэд НҮБ дангаараа энх тайвныг сахиулах ачааг үүрэх боломжгүй болсныг сүүлийн жилүүдийн үйл явдлууд баталж байна. Тиймээс олон талт хамтын ажиллагааны шинэ бүтэц, хэлбэрүүд эрчимтэй гарч ирж, бүс нутгийн байгууллагууд болох Африкийн Холбоо, Европын Холбоо, Умард Атлантын Гэрээний Байгууллагын үүрэг, оролцоо ЭСА-нд эрс нэмэгдэж, хамтарсан ажиллагаа (Hybrid missions)-ы шинэ хэлбэрүүд эрчимжлээ. Тухайлбал, 2025 онд Газын зурваст үүссэн хямралыг шийдвэрлэх зорилгоор НҮБ-ын мандат дор хэрэгжих холимог бүтэцтэй олон улсын Энхийн зөвлөл (“Board of Peace”) байгуулагдсан нь энхийг сахиулах архитектур

цаашид илүү төвлөрсөн бус, уян хатан хэлбэр рүү шилжиж буйг харуулж байна (World Bank., 2025).



Зураг 4. Кипр дэх UNFICYP ажиллагааны секторын зохион байгуулалт, хяналтын дэд бүтцийн байршил

Түүнчлэн орчин үеийн энхийг сахиулах ажиллагаа нь уламжлалт цэргийн үүрэгт суурилсан загвараас татгалзаж, технологи, мэдээлэл болон хүний аюулгүй байдлыг нэгтгэсэн цогц ажиллагааны хэлбэрт шилжиж байна. Энэхүү өөрчлөлтийн нөлөөгөөр аюулгүй байдлын орчин улам бүр олон талт, технологид суурилсан, мэдээллийн өрсөлдөөнт шинжтэй болсон юм. Сүүлийн үеийн судалгааны чиг хандлагад тулгуурлан энэхүү шинэ орчныг дараах үндсэн концепцүүдээр тодорхойлж болно. Үүнд:

- Хуурай газар, кибер орчин, мэдээллийн орон зай болон уур амьсгалын хүчин зүйлсийг хамарсан цогц ажиллагаа;
- Хиймэл оюун ухаан, нэгдсэн команд, удирдлага, хяналт, холбоо, тагнуулын систем (C4ISR), нисгэгчгүй нисэх төхөөрөмжид суурилсан тактикийн ажиллагаа;
- Худал мэдээлэл, нөлөөллийн кампанит ажил, мэдээллийн орчны манипуляцад тэсвэртэй байх чадамж;
- Энгийн иргэдийг хамгаалах, алба хаагчдын ёс зүйг чанд сахих болон олон улсын хууль эрх зүйн хүрээнд ажиллах зарчим гэх мэт байна.

Энэхүү нөхцөл байдал нь цэрэг хандивлагч орнуудад хоёр үндсэн шаардлагыг шинээр тавьж байна. Нэгдүгээрт, алба хаагчдын сургалт, бэлтгэлийн тогтолцоог чанарын шинэ түвшинд гаргаж, симуляци болон хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын уян хатан аргуудыг нэвтрүүлэх хэрэгцээ, хоёрдугаарт, орчин үеийн зэвсэглэл, C4ISR суурьтай холбоо-мэдээллийн систем, тандалт-хяналтын технологи, бие хамгаалах тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн стандарт, хүртээмжийг сайжруулах нь алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, амь нас, эрүүл мэндийг хамгаалах салшгүй урьдчилсан нөхцөл болж байна (UNDPO., 2025).

Энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал, тулгарч буй сорилтууд. НҮБ-

ын энхийг сахиулах ажиллагаа нь зэвсэг техник, мандат, дипломат бодлогоос гадна хүн хүчинд тулгуурласан үйл хэрэг юм. Гэвч геополитикийн ашиг сонирхлоос үүдэн ажиллагааны эрсдэл нэмэгдэж буй өнөө үед энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн баталгаа нь олон улсын түвшинд бүрэн шийдэгдээгүй, маргаантай сэдэв хэвээр байна. Энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал нь амь нас, эрүүл мэнд, санхүү-эдийн засаг болон нийгэм-сэтгэл зүйн гэсэн олон талт цогц ойлголт бөгөөд эдгээрийг тус тусад нь авч үзэх нь зүйтэй.

Энхийг сахиулах ажиллагаа хэзээ ч бүрэн “аюулгүй” байсан түүх үгүй бөгөөд алба хаагчид өдөр бүр үхэлтэй нүүр тулсан өндөр эрсдэлтэй бүсэд ажилладаг. Ажил үүргээ гүйцэтгэх явцад амь насаа алдсан, гэмтсэн, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд НҮБ-аас нөхөн олговор олгох механизмыг хэрэгжүүлдэг ч энэ нь алдагдсан амь насыг хэзээ ч бүрэн орлож чадахгүй.

НҮБ-ын ЭСА-ны албан ёсны веб-хуудаст байх статистик мэдээллээс харахад, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа эхэлсэн цагаас хойш өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 4,489 гаруй энхийг сахиулагч үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан байна. Эдгээр тоо баримтад дүн шинжилгээ хийхэд орчин үеийн ажиллагааны мөн чанар хэрхэн хувирсныг тод харж болно. Амь эрсэдсэн шалтгааныг харвал дараах байдалтай байна. Үүнд:

- Гэнэтийн дайралт, отолт - 1,676 тохиолдол. Энэ нь нийт амь эрсэдсэн тохиолдлын хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд энхийг сахиулагчид шууд халдлагын бай болж, байлдааны нөхцөлд үүрэг гүйцэтгэж буйг батлах хөдөлшгүй баримт юм.

- Өвчин эмгэг - 1,425 тохиолдол. Халуун орны халдварт өвчин (хумхаа, эбола вирус, шар чичрэг гэх мэт) болон эрүүл ахуйн хүнд нөхцөлөөс шалтгаалж байна.

- Осол гэмтэл - 1,143 тохиолдол. Хүлээн авагч улсын дэд бүтэц эвдэрсэн, зам тээврийн болон нисэхийн аюулгүй байдлын стандарт хангагдаагүй зэргээс үүдэлтэй.

- Бусад шалтгаан - 245 тохиолдол. Байгалийн гамшиг, амиа хорлолт зэрэг багтаж байна.

Эдгээр эрсдэлийн эсрэг НҮБ-аас ажиллагааны бүсэд эмнэлгийн шатлалтай (Level I, II, III) тусламж, яаралтай нүүлгэн шилжүүлэх (MEDEVAC/CASEVAC) үйлчилгээ болон даатгалын дэмжлэг үзүүлдэг. Харин үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа амь насаа алдсан тохиолдолд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолын дагуу ар гэрт нь дунджаар 75,000-аас 80,000 ам.долларын нөхөн олговор олгодог. Гэвч хүний амь насыг мөнгөөр хэмжих боломжгүйн зэрэгцээ, энэхүү мөнгийг ар гэрт нь олгох үйл явц нь тухайн илгээгч улсын Батлан хамгаалах, Сангийн яамдаар дамжин олон шат дараалалыг даван жинхэнэ эзэндээ олон сар, жилээр саатаж хүрэх, эсвэл дотоодын татварт суутгагдах зэрэг асуудлууд тулгарч байдаг.

Энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллын нэг чухал хэсэг нь НҮБ-аас олгодог санхүүгийн дэмжлэг юм. НҮБ нь ЭСА-д оролцож буй улс орнуудад дараах байдлаар санхүүгийн нөхөн олговор олгодог. Үүнд:

- НҮБ нь цэрэг илгээгч улсад нэг алба хаагчид ногдох стандарт нөхөн олговор олгодог (UNGA., 1976);

- Өндөр эрсдэлтэй ажиллагааны нөхцөлийг тооцсон нөхөн төлбөрийн

механизм болон осол, амь нас эндэхтэй холбоотой тусгай нөхөн олговор;

- НҮБ-ын тодорхой ангиллын ажилтан, цэргийн ажиглагч, штабын офицеруудад олгодог өдөр тутмын амьжиргаа (хоол, байр, унааны зардал г.м.)-ы тэтгэмж;

- Техник, тоног төхөөрөмж, логистик болон өөрийгөө хангах үйлчилгээний нөхөн олговор (COE) ([UN manuals., 2023](#)) зэрэг багтана.

Энэхүү асуудлын хүрээнд судлаачийн хувьд онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай нэгэн хүчин зүйл бол хуваарилалтын механизмын асуудал юм. Учир нь НҮБ-аас олгож буй дээрх санхүүжилт нь (томилолтын өдөр тутмын зардлаас бусад тохиолдолд) тухайн алба хаагчид биечлэн хуваарилагдах бус, харин илгээгч улсын төрийн санд буюу улсын төсөвт шууд төвлөрөн шилжүүлэгддэг эрх зүйн зохицуулалттай байдаг. Тухайн улсын Засгийн газар дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу түүнээс тодорхой хувийг суутган авч, үлдсэнийг нь цэрэгтээ цалин болгож өгдөг. Уг зохицуулалтын үр дагаварт тактикийн нэг орчинд, ижил түвшний амь насны эрсдэл үүрэн даалгавар гүйцэтгэж буй ялгаатай улс орнуудын алба хаагчдын хүртэх санхүүгийн бодит орлого хоорондоо зөрүүтэй байх тохиолдол гардаг.

Энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллын тогтолцооны онцлог нь НҮБ-ын институцийн шинж чанартай шууд холбоотой. Тодруулбал, НҮБ нь өөрийн байнгын зэвсэгт хүчингүй бөгөөд НҮБ-ын Дүрэмд заасны дагуу энхийг сахиулагчид нь зөвхөн тухайн ажиллагааны хугацаанд гишүүн орнуудаас (Цэрэг хандивлагч орнууд буюу TCCs / Цагдаа хандивлагч орнууд буюу RCCs) сайн дурын үндсэн дээр түр шилжүүлэн илгээсэн үндэсний зэвсэгт хүчний алба хаагчид байдаг. Энэхүү эрх зүйн онцлогоос шалтгаалан энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал нь үндэсний засгийн газар болон НҮБ-ын хооронд хуваарилагдсан хосолсон (shared responsibility)([UN manuals., 2023](#)) тогтолцоонд суурилдаг. Үүнд:

1. Энхийг сахиулагчдын нийгмийн үндсэн хамгаалалыг илгээгч улс буюу эх орон нь хариуцна. Алба хаагчийн үндсэн цалин, цэргийн тэтгэвэр, гэр бүлд үзүүлэх халамж, эрүүл мэндийн даатгал, албан хаагчийн карьерийн баталгаа зэрэг нь НҮБ-аас үл хамааран тухайн улсын Засгийн газрын үүрэг хэвээр үлддэг.

2. НҮБ нь ажиллагааны бүс дэх эмнэлгийн үйлчилгээ, аюулгүй байдлын хамгаалалт, түүнчлэн үүрэг гүйцэтгэх явцад амь насаа алдах, гэмтэл, бэртэл авахтай холбоотой нөхөн олговрын механизмыг хэрэгжүүлдэг.

Энэхүү хосолмол тогтолцооны гол зорилго нь энхийг сахиулагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд болон тэдний гэр бүлд санхүү, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, улмаар өндөр эрсдэлтэй орчинд үүрэг гүйцэтгэх суурь нөхцөлийг баталгаажуулахад оршдог. Гэвч практик дээр энэхүү хоёр институцийн (НҮБ болон Илгээгч улс) хоорондын уялдаа холбоо сул байгаагаас үүдэн алба хаагчид хохирох явдал цөөнгүй гардаг.

Энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллын асуудлыг зөвхөн цалин, нөхөн олговор, даатгалын хүрээнд ойлгох нь хангалтгүй юм. Судалгаануудын ([Carmona L., 2024](#)) дүнгээс үзэхэд мөргөлдөөн, хүчирхийлэл, аюултай орчинд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэх нь энхийг сахиулагчдын бие махбодын эрүүл мэндэд төдийгүй сэтгэл зүйн байдал, гэр бүл, нийгмийн харилцаанд урт хугацааны сөрөг нөлөө

үзүүлдэг байна. Иймээс энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллын асуудлыг зөвхөн эдийн засгийн бус, харин нийгэм, сэтгэл зүй, гэр бүл зэргийг хамарсан цогц тогтолцооны хүрээнд ойлгох шаардлагатай.

Энэхүү нийгэм-сэтгэл зүйн эрсдэлийн нэг томоохон хүчин зүйл нь гэр бүлээсээ удаан хугацаагаар хол байх явдал юм. Энхийг сахиулагчид ихэвчлэн 6 сараас 1 жил (зарим тохиолдолд түүнээс ч урт) хугацаагаар хээрийн ажиллагаанд томилогддог. Олон сар, жилээр гэр бүлээсээ хол, эрсдэл өндөр орчинд байх нь гэр бүлийн харилцаанд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг гэдгийг олон судалгаанаас харж болно. Удаан хугацаагаар алслагдсан бүс нутагт үүрэг гүйцэтгэх нь алба хаагчдын гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж, үл ойлголцол үүсэх, улмаар гэр бүл салах хүртэлх эрсдэлийг дагуулж байна. үүнчлэн, алба хаагчид хүүхдийнхээ өсөлт хөгжил, төлөвшлийн чухал үе шатуудад биечлэн оролцох боломжгүй байх нь эцэг эхийн үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байна гэх дотоод сэтгэл зүйн зөрчил үүсгэх, гэм буруугийн мэдрэмж нэмэгдэх зэрэг сэтгэл зүйн нарийн төвөгтэй асуудлуудыг бий болгодог. Үүнээс гадна, өөр улс, огт өөр соёл, уур амьсгалтай орчинд үүрэг гүйцэтгэх нь бие махбод төдийгүй оюун санааны маш том сорилт юм. НҮБ-ын ажиллагаа нь олон үндэстний цэргүүдээс бүрддэг тул бүлэг доторх хэлний бэрхшээл нь үл ойлголцол үүсгэх, үйл ажиллагаанд сөрөг нөлөө авчрах эрсдэлтэй. Мөн орон нутгийн иргэдийн зан заншил, шашны ялгаатай байдлыг үл ойлгосноос үүдэн энгийн иргэдтэй зөрчилдөх тохиолдол гардаг. Жишээлбэл, Исламын шашинтай улс орнуудад үүрэг гүйцэтгэж буй өөр шашинтай цэргүүд орон нутгийн эмэгтэйчүүдтэй харилцах, мөргөлийн газрын хажуугаар өнгөрөх зэрэгт гаргасан санамсаргүй үйлдэл нь стратегийн түвшний мөргөлдөөн болж хувирах аюултай байдаг. Энэхүү сонор сэрэмжтэй байж, өөрийн үйлдэл, харилцааг тасралтгүй хянах шаардлага нь алба хаагчдын сэтгэл зүйн ачааллыг нэмэгдүүлж, удаан хугацаанд үргэлжилсэн стресс болон ядаргаанд хүргэх эрсдэлийг бий болгодог.

Нөгөө талаас, ЭСА-д үүрэг гүйцэтгээд эх орондоо буцаж ирсний дараах нийгэмтэй дасан зохицох үйл явц нь нийгмийн хамгааллын хамгийн орхигдсон сэдэв юм. Байлдааны нөхцөл, үхэл хагацал, өлсгөлөн, хүчирхийллийг өдөр бүр нүдээр үзэж, байнгын өндөр хариуцлага, сэтгэл зүйн онцгой бэлтгэл шаардсан орчинд ажилласан цэргүүд тайван цагийн нийгэмд эргэн дасан зохицоход хүндрэлтэй байдаг. Нойргүйдэх, согтууруулах ундаанд дурлах, уур уцаартай болох, сэтгэл зүйн тогтвортой байдлаа алдах зэрэг сэтгэл санааны өөрчлөлт, стрессийн эмгэгийн шинж тэмдэг олон алба хаагчдад илэрдэг. Гэвч дэлхийн олон орнуудад “цэргийн хүн хатуужилтай байх ёстой” гэх хэвшмэл ойлголтоос үүдэн сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээг албан ёсоор төрөөс хариуцаж хийдэггүй нь алба хаагчдын цаашдын ажил, амьдралын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Дүгнэлт

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа нь төсвийн таналт, хүн хүчний хомсдол дунд, төрийн бус зэвсэгт бүлэглэлүүдтэй нүүр тулж, энгийн иргэдийг хамгаалах хүндхэн мандат дор үйл ажиллагаагаа явуулж байна. Энэхүү байнгын стресстэй, аюул заналхийлсэн эрсдэлтэй орчин нь алба хаагчдаас зөвхөн цэргийн ур чадвар төдийгүй сэтгэл зүйн асар их тэсвэр тэвчээр шаардаж байгаа бөгөөд энэ нь цаашлаад энхийг сахиулагчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн баталгааг

нэн тэргүүнд шийдвэрлэх ёстойг харуулж байгаа юм.

Дэлхий дахины геополитикийн тэмцэл, технологийн шинэчлэл, төсвийн таналт нь НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааг зогсоохгүй ч улам илүү аюултай, шаардлага өндөртэй талбар руу хөтөлж байна. Кипр (UNFICYP) зэрэг уламжлалт хурцадмал бүсүүдээс эхлээд Африк, Ойрх Дорнодын зэвсэгт мөргөлдөөний голомтод үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчид бол олон улсын энх тайвныг тогтоогч гол тулгуур юм. Энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллыг хангах нь зөвхөн алба хаагчдын эрх ашиг, сайн сайхан байдлыг хамгаалах хүмүүнлэгийн асуудал бус, энхийг сахиулах ажиллагааны үр нөлөө, тогтвортой байдал, хүний нөөцийн чадавхыг хадгалах стратегийн ач холбогдолтой бодлогын чиглэл юм. Энхийг сахиулагчид өндөр эрсдэлтэй, сэтгэл зүйн ачаалал ихтэй орчинд үүрэг гүйцэтгэдэг тул тэдний нийгмийн хамгааллыг санхүүгийн нөхөн олговороор хязгаарлах бус, эрүүл мэнд, сэтгэл зүй, гэр бүлийн дэмжлэгийг хамарсан цогц тогтолцооны хүрээнд авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын хувьд энхийг сахиулагчдын нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгохын тулд ажиллагааны дараах сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ, эрүүл мэндийн урт хугацааны хяналт, гэр бүлийн дэмжлэгийн механизмыг институцийн түвшинд бэхжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн энхийг сахиулах ажиллагаанд оролцсон алба хаагчдын туршлага, онцгой эрсдэлийг харгалзан нийгмийн баталгаа болон хүний нөөцийн бодлоготой уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь Монгол Улсын энхийг сахиулах чадавх, тогтвортой оролцоог дэмжих чухал нөхцөл болно.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Carmona L., 2024. “UN’s Mind Companion Web and Mobile Application Provides Essential Mental Health Support to UN Peacekeepers.” *United Nations Peacekeeping*.
2. Duursma A., Sara Lindberg Bromley, and Aditi Gorur. 2024. “The Impact of Host-State Consent on the Protection of Civilians in UN Peacekeeping.” *Civil Wars* 26 (1): 16–40. <https://doi.org/10.1080/13698249.2023.2196185>.
3. UN manuals., 2023. “Contingent-Owned Equipment Manuals and Policies.” United Nations Peacekeeping Resource Hub.
4. UN Reports., 2026. “Troop and Police Contributors Report (2025-2026).”
5. UNDP., 2025. “Peacekeeping Training and Capacity Building in Complex Environments.” United Nations.
6. UNDP., 2026. “Information Integrity and Peacekeeping Operations. United Nations. (2025–2026). Troop and Police Contributors Report.” United Nations Department of Peace Operations.
7. UNFICYP., 2024. “United Nations Peacekeeping Force in Cyprus. (2024). About the Buffer Zone.” United Nations Peacekeeping. World Bank.
8. UNFILL reports. 2026. “UNIFIL Incident Reports.” United Nations Peacekeeping.
9. UNGA., 1976. “Rates of Reimbursement to Troop-Contributing Countries and Other Related Issues (A/RES/76/274).” United Nations.

10. UNISFA Reports. 2025. “Reports on UNISFA Casualties and Security Situation.” United Nations Security Council.
11. United Nations. 2023. “Report on Peacekeeping Transitions and Withdrawals.” New York: United Nations.
12. World Bank., 2025. “Gaza Reconstruction and Transitional Governance Framework Briefing.”